МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

2025

ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ №21

70282853

nczd@nczd.gov.mn

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

Б.Амгаланбаяр, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал,
Нийгмийн эрүүл мэндийн магистр

ХЯНАН ТОХИОЛДУУЛАСАН

Б.Лхагвасүрэн, Цахим хөгжлийн албаны дарга

ЭМХЭТГЭСЭН

Н.Саруулчулуун, Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны халдвар судлагч

МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭСЭН

1. Э.Пагмадулам: Хүний нөөцийн мэдээлэл
2. Н.Саруулчулуун: Зоонозын өвчлөлийн мэдээлэл
3. М.Даваадорж: Тарваган тахал өвчний байгалийн голомтын мэдээлэл
4. Г.Ганбилэг: Боомын голомт, хяналтын шинжилгээ
5. Б.Чимэдциеэ, Ж.Батцэцэг: Хачигт халдварын мэдээлэл
6. Ц.Отгонцэцэг: Холерын хяналтын шинжилгээний мэдээлэл
7. С.Мөнгөнбагана: Шувууны томуугийн тандалтын мэдээлэл
8. Б.Болорчимэг: Шумуулаар дамжих халдварын тандалтын мэдээлэл
9. Н.Саруулчулуун: Зоонозын өвчний дархлаажуулалт
10. У.Өнөрсайхан, Ч.Буянхишиг: Лабораторийн шинжилгээний тоон мэдээлэл
11. Ц.Хишигжаргал, Д.Мөнх-Эрдэнэ: Биоүйлдвэрлэлийн үйл ажиллагаа
12. Г.Зулцэцэг: Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа
13. Х.Цэрэнсүрэн: Эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээлэл
14. Б.Цэвэлсүрэн: Төгсөлтийн дараах сургалтын мэдээлэл
15. Л.Роломжав, А.Бямбахишиг: Сургалт, сурталчилгааны мэдээлэл
16. Ч.Бат-Ирээдүй: Шуурхай удирдлагын нэгжийн тоон мэдээлэл

Энэхүү эмхэтгэлийн талаар саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Утас +976 70282859, Цахим хаяг: nczd@nczd.gov.mn,

ӨМНӨХ ҮГ

Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймаг, Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн тайлан, мэдээ, Зоонозын өвчний бүртгэл мэдээллийн системд үндэслэн зоонозын өвчний статистик мэдээллийг эмхэтгэн 21 дэх дугаарыг та бүхэнд хүргэж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээлснээр одоогоор мэдэгдэж буй халдварт өвчний 60 орчим хувь, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний 75 орчим хувь нь амьтнаас хүнд дамждаг зоонозын гаралтай өвчин байна. Уур амьсгалын өөрчлөлт, хотжилт, байгалийн экосистемийн доройтол зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр зоонозын халдварын эрсдэл нэмэгдэж байгаа бөгөөд сүүлийн үед шувууны томуугийн A(H5N1) вирус, Эбола, Нипах вирус зэрэг халдварууд дэлхийн нийтийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал хэвээр байна.

Эдгээр халдварууд нь Монгол Улсад нутагшмал бус боловч зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлтэй бөгөөд тарваган тахал, боом, бруцеллёз зэрэг нутагшмал халдварууд тогтмол бүртгэгдсээр байна. Иймд зоонозын халдварын эрсдэлийг бууруулах, өвчлөл, дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгалийн голомт болон хүний өвчлөлийн үзүүлэлтүүдийг тогтмол хянах нь чухал юм.

Монгол улсад 30 гаруй зоонозын халдварыг оношлон бүртгэж байгаагаас 10 гаруй халдвар жил бүр тогтмол бүртгэгдэж байна. Хүний өвчлөл сүүлийн жилүүдэд буурч байгаа хэдий ч зарим өвчлөл зөөвөрлөгдөн орж ирэхийн зэрэгцээ шинэ халдвар бүртгэгдэж байна.

2025 онд улсын хэмжээнд зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй 813, амьтны 226 дуудлага бүртгэгдсэн байна. Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол өмнөх оноос 16,9 хувиар буурсан, сүүлийн 5 жилийн дунджаас 7,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт бүртгэгдсэн сэжигтэй дуудлагын 11,6% нь эмнэлзүй, тархвар судлал, лабораториийн шинжилгээгээр онош батлагдаж, 2 нас баралт бүртгэгдсэн. Мөн бруцеллёзын халдвар тус төвд мэдээлэгдээгүй ч онош нь баталгаажиж улсын мэдээнд бүртгэгдсэн тохиолдол цөөнгүй байна. Нийт батлагдсан тохиолдлоос хачигт халдвар болон бруцеллёзын халдвар дийлэнх хувийг эзэлж, гахайн стрептококкын халдвар шинээр бүртгэгджээ.

2025 онд бүртгэгдсэн зоонозын хүний өвчлөл 10000 хүн амд 0,4 байгаа нь өмнөх онтой ижил түвшинд, сүүлийн 10 жилийн дунджаас 0,28-аар буурсан байна.

Энэхүү эмхэтгэлд тусгагдсан тоо баримт нь салбарын ололт амжилт, онцлог нөхцөл байдлыг харуулахын зэрэгцээ цаашид анхаарч шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлж байна.

Тус эмхэтгэл нь зоонозын салбарын мэргэжилтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажил, өвчний тандалт, хариу арга хэмжээ, цаашдын бодлого, төлөвлөлтөд ашиглах нотолгоонд суурилсан мэдээллийн эх сурвалж болно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү эмхэтгэлийг хамтран боловсруулсан Зоонозын өвчин судлалын салбарын нийт хамт олондоо талархал илэрхийлье.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Б.АМГАЛАНБАЯР

ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1. Монгол улсын хүн амын тоо, 2021-2025 он 8
Хүснэгт 2. Монгол улсын малын тоо, 2021-2025 он 9
Хүснэгт 3. 2025 оны хүний нөөцийн тоон үзүүлэлт, аймгаар 12
Хүснэгт 4. Халдварт өвчний тохиолдлын тоо, нас баралт, төрлөөр, 2024-2025 он 14
Хүснэгт 5. Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоон үзүүлэлт, 2020-2025 он 16
Хүснэгт 6. Зоонозын хүний өвчлөлийн тоо, өвчний төрөл, аймгаар, 2025 он 20
Хүснэгт 7. Зоонозын хүний өвчлөлийн тоо, өвчний төрлөөр, 2016-2025 он 21
Хүснэгт 8. Тарваган тахлын батлагдсан тохиолдлын тоо, нас баралт, 1970-2025 он 23
Хүснэгт 9. Тарваган тахал өвчний өвчллөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 24
Хүснэгт 10. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын 25
Хүснэгт 11. Боомын хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 27
Хүснэгт 12. Боомын хяналтын шинжилгээний дүн, сорьцын төрлөөр, аймгаар, 2025 он 29
Хүснэгт 13. Боомын голомт хяналтын шинжилгээний дүн, сорьцын төрлөөр, аймгаар, 2025 он 30
Хүснэгт 14. Боомын голомт, хяналтын шинжилгээний дүн, 2020-2025 он 30
Хүснэгт 15. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол (2020-2025 он) 31
Хүснэгт 16. Хачигт энцефалит өвчний хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 32
Хүснэгт 17. Хачигт риккетсиозын тохиолдлын тоо, нас баралтын түвшин, 2024-2025 он 33
Хүснэгт 18. Хачигт боррелиоз өвчний хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 34
Хүснэгт 19. Хачгаар дамжих өвчний тандалт шинжилгээнд хамрагдсан байдал, 2020-2025 он 35
Хүснэгт 20. Галзуугийн хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 38
Хүснэгт 21. Хумхаагийн өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 39
Хүснэгт 22. Холерын хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 41
Хүснэгт 23. Холерын хяналтын шинжилгээний үзүүлэлт, 2024-2025 он 42
Хүснэгт 24. Холерийн хяналтын шинжилгээний үзүүлэлт, 2020-2025 он 43
Хүснэгт 25. Бэтэгийн хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 44
Хүснэгт 26. Бруцеллёзын хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он 45
Хүснэгт 27. Шувууны тооллогын дүн, 2025 он 47
Хүснэгт 28. Шумуулын тандалт, 2020-2025 он 48
Хүснэгт 29. Мал, амьтны зоонозын өвчний тоо, өвчний төрлөөр, аймгаар, 2025 он 49
Хүснэгт 30. Мал, амьтны зоонозын өвчний тоо, амьтны төрлөөр, 2025 он 50
Хүснэгт 31. Мал, амьтны зоонозын өвчний үзүүлэлт, 2021-2025 он 50
Хүснэгт 32. Эерэг сорьцын эзлэх хувь, халдварын төрлөөр, 2025 он 55
Хүснэгт 33. Ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний ажлын үзүүлэлт, 2020-2025 он 56
Хүснэгт 34. Биоүйлдвэрлэлийн лабораторид үйлдвэрлэсэн 58

Хүснэгт 35. 2025 онд БҮЛ-д үйлдвэрлэсэн үндсэн тэжээлт орчин, зарим төрлийн ялган оношлох тэжээлт орчин, будаг урвалж, бактериофаг, будагтай цаасны хэмжээ, харьцуулалт 58

ЗУРГИЙН ТАЙЛБАР

Зураг 1. Зоонозын өвчин судлалын төвүүдийн байршил 10
Зураг 2. 2025 оны зоонозын салбарын хүний нөөц 11
Зураг 3. Зоонозын өвчин судлах байгууллагуудын хүний нөөц, 2025-2026 он 13
Зураг 4. ЗӨСҮТ-ийн эрдмийн зэрэгтэй ажилчдын тоон үзүүлэлт, 2022-2025 он 13
Зураг 5. Халдварт өвчний нас баралт, төрлөөр, 2024-2025 он 14
Зураг 6. Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоо, аймгаар, 2025 он 15
Зураг 7. Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдын эзлэх хувь, 2025 он 16
Зураг 8. Мэрэгчийн дуудлагын тоон үзүүлэлт, 2021-2025 он 17
Зураг 9. Мэрэгчийн дуудлагад үйлчилсэн тоо, аймгаар, 2025 он 17
Зураг 10. ЗӨСҮТ-ийн мэрэгчийн дуудлагаар хураагдсан амьтны тоо, аймгаар, 2025 он 18
Зураг 11. Зоонозын хүний өвчлөлийн батлагдсан тохиолдлын тоо, аймгаар, 2025 он 19
Зураг 12. Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол, өвчлөл, нас баралтын тоо, 2016-2025 он 21
Зураг 13. Зоонозын хүний өвчлөл, 10000 хүн амд, 2016-2025 он 22
Зураг 14. Тарваган тахлын хүний өвчлөлийн тоо , 2016-2025 он 23
Зураг 15. 1 га-д ногдох мэрэгчийн нягтшил, 2021-2025 он 25
Зураг 16. Байгалийн голомтын тандалт шинжилгээгээр илэрсэн тарваган тахлын 26
Зураг 17. Тарваган тахлын аюулын зэрэглэл, 2025 он 26
Зураг 18. Боомын хүний өвчлөлийн тохиолдлын тоо, 2016-2025 он 27
Зураг 19. Боомын хүн, малын өвчлөлийн тоо, 2016-2025 он 28
Зураг 20. Шинжилсэн сорьцын тоо, 2016-2025 он 29
Зураг 21. Хачигт халдварын сэжигтэй тохиолдлын тархалтын муруй, 2025 он 31
Зураг 22. Хачигт риккетсиозын өвчлөл, аймгаар, 2025 он 33
Зураг 23. Хачигт халдварын тандалт шинжилгээ хийсэн газар, цэгүүд, 2025 он 35
Зураг 24. Тандалт судалгаанд хамрагдсан газрууд, 2025 он 36
Зураг 25. Галзуугийн эрсдэлд өртсөн тохиолдлын тоо, эпидемиологийн долоо хоногоор 37
Зураг 26. Хумхаагийн хүний өвчлөлийн тоо, 2021-2025 он 40
Зураг 27. Холерын хяналтын шинжилгээнд цуглуулсан сорьцын төрөл, 2025 он 42
Зураг 28. Бруцеллёзын хүний өвчлөл, аймгаар, 2025 он 46
Зураг 29. Шувууны томуугийн эрсдэлийн зураг (хүн ам, мал амьтан, нүүдлийн шувуудын тоон мэдээг үндэслэж эрэмбэлэв) 47
Зураг 30. Мал, амьтны зоонозын өвчний тоо, 2025 он 49
Зураг 31. Тарваган тахлын дархлаажуулалт, 2016-2025 он 51
Зураг 32. Хачигт энцефалитын дархлаажуулалт (2016-2025 он) 51
Зураг 33. Галзуугийн вакцинд хамрагдсан үзүүлэлт, 2016-2025 он 52

Зураг 34. Галзуугийн эсрэг вакцины хамрагдалтын тоон үзүүлэлт, аймгаар, 10000 хүн амд.....52
Зураг 35. Галзуугийн эсрэг вакцины хамрагдалтын түвшин, дүүргээр, 10000 хүн амд.....53
Зураг 36. Лабораторийн шинжилгээний тоон үзүүлэлт, 2016-2025 он.....54
Зураг 37. Лабораторийн шинжилгээний төрөл, 2025он 54
Зураг 38. Лабораторийн шинжилгээний төрлүүд, 2025 он.....55
Зураг 39. Ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний ажлын үзүүлэлт, 2020-2025 он 57
Зураг 40. Эрдэм шинжилгээний ажлын тоон үзүүлэлт, 2021-2025 он.....61
Зураг 41. Зоонозын салбарын хүний нөөцийн сургалтад хамрагдсан байдал, 2025 он 61
Зураг 42. Мэргэшүүлэх болон дагалдан сургалтын үзүүлэлт, 2021-2025 он.....62

БҮЛЭГ НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол улсад 2025 оны байдлаар 3,6 сая хүн ам тоологдсон нь өмнөх оны үзүүлэлтээс 1,02 хувиар өссөн байна. Мөн нийт хүн амын 1,8 сая орчим буюу 50,01 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байна. Хүн амын тоог бүс нутгаар харьцуулж үзэхэд баруун бүсэд 11,8% буюу хамгийн олон хүн ам оршин сууж байна. Аймгуудаар харьцуулж үзэхэд Хөвсгөл аймаг 137 878 буюу хамгийн олон хүн амтай байгаа бол Говьсүмбэр аймаг 18 758 буюу хамгийн бага хүн амтай байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Монгол улсын хүн амын тоо, 2021-2025 он

Нэгж	2021	2022	2023	2024	2025
Улсын дүн	3419654	3467263	3514456	3554550	3591120
Хангайн бүс	607497	604494	604026	603664	607553
Архангай	94342	93286	92480	91696	92580
Баянхонгор	89121	88475	88244	88107	89339
Өвөрхангай	115991	115221	114889	114610	115634
Булган	62042	61260	60634	60431	60630
Орхон	108934	109346	110661	112111	111492
Хөвсгөл	137067	136906	137118	136709	137878
Баруун бүс	420013	420113	421270	424251	426062
Баян-Өлгий	113492	115432	117271	118931	119344
Говь-Алтай	57969	57249	56903	56674	56831
Завхан	72816	71883	71211	70804	71049
Увс	84279	84148	84098	85095	85396
Ховд	91457	91401	91787	92747	93442
Төвийн бүс	519228	516655	519111	522551	529919
Дархан-Уул	107982	108163	109467	110775	111244
Сэлэнгэ	109125	107588	106938	106289	107713
Төв	93670	92240	91653	91757	94057
Говьсүмбэр	18173	18030	18065	18182	18758
Дорноговь	71540	71212	71600	72180	72515
Дундговь	46950	46417	46122	45930	46577
Өмнөговь	71788	73005	75266	77438	79055
Зүүн бүс	227791	228282	229248	229980	231541
Дорнод	83878	83825	84174	84725	84991
Сүхбаатар	64771	65323	65805	65900	66611
Хэнтий	79142	79134	79269	79355	79939
Улаанбаатар	1645125	1697719	1740801	1774104	1796045

Эх сурвалж: ХҮН АМЫН ТОО, байршил, аймаг, нийслэл, жилээр by Байршил, Бүс and Он. PxWeb

1.2. МОНГОЛ УЛСЫН МАЛЫН ТОО

Монгол улсад 2025 оны жилийн эцсийн байдлаар малын тоо 58,094,7 сая болж, өмнөх оноос 445,1 мянга буюу (0,8) хувиар өссөн байна. Малын төрлөөр задалбал 5,1 сая адуу, 5,4 сая үхэр, 501,3 мянган тэмээ, 23,9 сая хонь, 23,2 сая ямаа тоологдлоо.

Өмнөговь, Сүхбаатар, Архангай, Хэнтий, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Хөвсгөл, Дорнод, Говьсүмбэр, Завхан аймгууд болон Улаанбаатар хотод малын тоо өмнөх оноос 10,7-325,0 мянгаар өссөн.

Сэлэнгэ, Увс, Ховд, Баян-Өлгий, Дархан-Уул, Өвөрхангай, Булган, Говь-Алтай, Төв, Орхон аймгуудад малын тоо өмнөх оноос 6,3-354,5 мянгаар буурсан (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Монгол улсын малын тоо, 2021-2025 он

Нэгж	2021	2022	2023	2024	2025
Улсын дүн	67,343.7	71,120.4	64,681.88	57,647.9	58,094,7
Баруун бүс	16448.0	16131.0	14316.2	14655.2	13776,9
Завхан	3755.1	3721.0	3067.5	3008.2	3028,1
Говь-Алтай	2990.5	3167.4	3013.2	3095.2	3035,7
Баян-Өлгий	2379.0	2255.8	2046.0	2125.1	1918,9
Ховд	3596.9	3472.8	3194.8	3491.1	3183,0
Увс	3726.3	3513.8	2994.4	2935.5	2611,2
Хангайн бүс	22432.0	24512.9	23114.5	21623.9	22,118,0
Орхон	154.5	169.9	175.3	175.8	169,6
Өвөрхангай	4022.6	4590.4	4734.6	5137.9	5063,9
Булган	3622.2	3892.8	3622.8	3038.7	2978,6
Баянхонгор	3127.1	3719.5	4072.2	4027.0	4231,9
Архангай	5562.1	5886.0	4847.4	4082.2	4362,2
Хөвсгөл	5943.2	6254.0	5662.0	5162.0	5311,9
Төвийн бүс	15811.3	16970.9	15411.7	13103.0	13,343,7
Төв	4746.0	5107.6	4933.0	4150.0	4121,8
Говьсүмбэр	432.1	464.2	450.1	290.6	324,0
Сэлэнгэ	1886.7	1912.3	1769.4	1602.4	1248,0
Дорноговь	2706.7	2909.6	2294.8	1451.9	1644,0
Дархан-Уул	355.3	313.2	261.2	252.2	163,1
Өмнөговь	2513.8	2637.3	2042.0	1970.1	2295,1
Дундговь	3170.4	3626.3	3661.1	3385.4	3547,7
Зүүн бүс	12208.9	13063.6	11412.1	7852.8	8432,6
Дорнод	3051.0	3342.3	3151.7	2652.2	2694,7
Сүхбаатар	4202.9	4644.7	3859.4	2008.8	2308,8
Хэнтий	4954.9	5076.5	4400.9	3191.7	3429,1
Улаанбаатар	443.3	442.8	427.1	412.7	423,6

Эх сурвалж: https://mofa.gov.mn/files/pdf-files/a5csr9t4788/695dd30d83d7de7c1b04c7ac.pdf

Улсын хэмжээнд зоонозын өвчин судлах чиглэлээр 15 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Улаанбаатар хотод 1931 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бол орон нутагт хамгийн анх 1937 онд Завхан аймагт, хамгийн сүүлд 2004 онд Сэлэнгэ аймагт тус тус Зоонозын өвчин судлалын төв байгуулагдаж байжээ. Монгол улс нь нүүдлийн аж амьдралтай бөгөөд өдөр тутамдаа мал, амьтантай харьцах замаар орон нутгийн иргэд зоонозын халдвараар өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амд хамаардаг. Иймээс цаашид зоонозын өвчин судлах төвгүй Булган, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймагт зоонозын өвчин судлалын төвийг шинээр байгуулах хэрэгцээ шаардлага өндөр байна (Зураг 1).



Зураг 1. Зоонозын өвчин судлалын төвүүдийн байршил

Зоонозын салбарт ажиллаж буй 401 албан хаагчийн 45,5% (183) нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 31,1% (125) нь бусад дээд мэргэжилтэн, 16,8% (67) нь эмнэлгийн туслах ажилтан, 6,4% (26)-ийг удирдлагууд тус тус эзэлж байна. Эмч, эмнэлгийн 183 мэргэжилтнүүдийн 36,6% бага эмч, лаборантууд, бусад салбарын 125 дээд мэргэжилтнүүдээс 21,2% нярав нягтлан, эмнэлгийн туслах 67 ажилтнаас жолооч, жижүүр 64,4% тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Үүнээс харахад тус төв нь бусад эрүүд мэндийн салбар байгууллагуудаас хүний нөөцийн онцлогтой нь харагдаж байна (Зураг 2).



Зураг 2. 2025 оны зоонозын салбарын хүний нөөц

Хүснэгт 3. 2025 оны хүний нөөцийн тоон үзүүлэлт, аймгаар

Үзүүлэлт		ЗӨСҮТ	Баян-Өлгий	Хөвсгөл	Сэлэнгэ	Увс	Өвөрхангай	Завхан	Багануур	Архангай	Говь-Алтай	Хэнтий	Ховд	Баянхонгор	Өмнөговь	Дундговь	Нийт
Удирдлага		9	1	1	1	1	2	1	1	1	1	1	3	1	1	1	26
Их эмч	Халдвар судлагч	10	2	2	1	1	2	1	3	2	1	2	0	2	1	1	31
	Клиникийн их эмч	1										0,5	2				3,5
	Лабораторийн эмч	9	2	2	2	1	1	2	2	3	2	3	2	3	2	1	37
	Бүгд	**29**	**5**	**5**	**4**	**3**	**5**	**4**	**6**	**6**	**4**	**6,5**	**7**	**6**	**4**	**3**	99,5
Бусад дэд мэргэжилтэн	Амьтан судлагч	4	2	3	1	1	1	1	1	2	1	1	2	1	1	1,5	23,5
	Шимэгч судлагч	3	1	1	1	1	1	1		1	1	1	1	1	1		15
	Биотехнологич	3															3
	Генетикч	2				1				1		1	1				6
	ИТА, МТехнологийн мэргэжилтэн	4		1		1		1	1	1				1	1		11
	Эм зүйч	4															4
	Биохимич	1															1
	Лаборторийн амьтаны мэргэжилтэн	1															1
	Хүний нөөц бичиг хэрэг	3		1		2	2	1	2	1		2	2	2	1	1	20
	Нягтлан нярав	3	2	2	1	2	2	1	2	2	1	2	2	2	1	1,5	26,5
	Менежер мэргэжилтэн	9	1		1	1	1	1		1		1	3				19
	Бүгд	**34**	**6**	**8**	**4**	**9**	**7**	**6**	**6**	**9**	**3**	**8**	**11**	**7**	**5**	**4**	130
	Бага эмч,лаборант	13	7	6	4	6	3	3		3		3	4	6	2	1,5	66,5
	Бүгд	**13**	**7**	**6**	**4**	**6**	**3**	**3**		**3**		**3**	**4**	**6**	**2**	**1,5**	66,5
Бусад эмнэлгийн мэргэжилтэн	Ариутгагч,	6	2	3	1	1	1	1	2	2	3	1,5	1	2	1	1	28,5
	Бэлдмэлчин	3	**1**			1			1	1		1,5	1	2			12,5
	Бүгд	**9**	**3**	**3**	**1**	**2**	**1**	**1**	**3**	**3**	**3**	**3**	**2**	**4**	**1**	**1**	41
Эмнэлгийн туслах ажилтан	Жолооч, жижүүр	7	3	4	1	2	1	1	4	4	4	1,5	3	5	1	2	43,5
	Үйлчлэгч, галч, слесарь	5	3	1	0	2	1	1	1	2	1	4		1	1	1	24
	Бүгд	**11**	**7**	**7**	**1**	**5**	**2**	**4**	**6**	**8**	**5**	**6**	**5**	**6**	**2**	**3**	78
Ажилласан орон тоо		100	27	27	15	23	18	15	20	27	20	20	27	29	14	12,5	401,5

Нийт Зоонозын өвчин судлах байгууллагын хүний нөөц 2025 онд 416 байсан бол 2026 онд 401 хүн ажиллаж байна. Өмнөх оноос 15 буюу 3,6 хувиар буурсан байна.

ЗӨСҮТ болон, Ховд , Хөвсгөл аймгийн хүний нөөцийн тоо буурсан үзүүлэлт ажиглагдаж байна (Зураг 3).



Зураг 3. Зоонозын өвчин судлах байгууллагуудын хүний нөөц, 2025-2026 он

2025 оны жилийн эцсийн байдлаар ЗӨСҮТ-д дэд профессор 1, Анагаах ухааны доктор 2, Биологийн ухааны доктор 1, Мал эмнэлгийн ухааны доктор 1, анагаахын болон биологийн шинжлэх ухааны магистр 22 тус тус ажиллаж байна.

Зоонозын өвчин судлалын салбарт Зөвлөх зэрэгтэй 1, Тэргүүлэх зэрэгтэй 2 , Ахлах зэрэгтэй 4 мэргэжилтнүүд ажиллаж байна (Зураг 4).



Зураг 4. ЗӨСҮТ-ийн эрдмийн зэрэгтэй ажилчдын тоон үзүүлэлт, 2022-2025 он

БҮЛЭГ ХОЁР. ЗООНОЗЫН ӨВЧНИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 52882 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 154,0 ногдож байна. Нийт халдварт өвчний 57,9 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 19,7 хувь нь бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 11,0 хувь нь гэдэсний халдварт өвчин, 0,3 хувь нь зоонозын халдварт өвчин, 11,1 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад гэдэсний халдварт өвчин 27,8 хувь, бэлгийн замаар дамжих халдварт өвчин 16,9 хувь, зоонозын халдвар 12,3 хувиар тус тус буурсан бол амьсгалын замын халдвар 48,8 хувиар нэмэгдсэн байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Халдварт өвчний тохиолдлын тоо, нас баралт, төрлөөр, 2024-2025 он

№	Халдварт өвчний төрөл	Өвчлөл			Нас баралт		
		2024	2025	Өсөлт/Бууралт	2024	2025	Өсөлт/Бууралт
1	Амьсгалын замын халдварт өвчин	15576	30440	14864	48	63	15
2	Бэлгийн замын халдварт өвчин	12111	10392	-1760	2	9	7
3	Гэдэсний халдварт өвчин	7463	5840	-1623	1	0	-1
4	Зоонозын халдварт өвчин	155	138	-17	3	1	-2
5	Цусаар дамжих халдварт өвчин	173	179	6	9	4	-5
6	Бусад халдварт өвчин	5333	5893	560	6	3	-3
7	Нийт	40852	52882	12030	67	80	11

Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлт 2025

Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар халдварт өвчний нас баралтын 80 тохиолдол бүртгэгдсэнээс сүрьеэ (46), улаанбурхан (11), төрөлхийн тэмбүү (9), менингококк халдвар (5), вируст гепатит (5), бэтэг (1), ёлом (1), тарваган тахал (1), бусад өвчлөл (1) тус тус бүртгэгдсэн байна (Зураг 5).



Зураг 5. Халдварт өвчний нас баралт, төрлөөр, 2024-2025 он

Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлт 2025

2.2.1. ЗООНОЗЫН ХҮНИЙ ӨВЧЛӨЛИЙН СЭЖИГТЭЙ ДУУДЛАГА

Улсын хэмжээнд зоонозын хүний өвчлөлийн 13 төрлийн 813 сэжигтэй тохиолдлын дуудлага хүлээн авч хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Нийт бүртгэгдсэн дуудлагыг аймгаар харьцуулж үзэхэд Ховд аймагт 196 буюу хамгийн их, Дархан-Уул, Дорноговь, Сүхбаатар аймгуудад дуудлага хамгийн бага бүртгэгдсэн (Зураг 6).



Зураг 6. Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоо, аймгаар, 2025 он

Сэжигтэй тохиолдлыг өвчний төрлөөр харьцуулан үзвэл галзуугийн эрсдэлд өртсөн 327 (40,2%), хачигт риккетсиоз 383 (47,1%), хачигт энцефалит 39 (4,8%), хачигт бореллиоз 5 (0,6%), бэтэг 23 (2,8%), хумхаа 8 (1,0%), тарваган тахал 14 (1,7%), боом 7 (0,9%), холер 3 (0,4%), гахайн стрептококк (Streptococcus suis), токсоплазмоз, бруцеллёз, лептоспироз тус тус 1 (0,1) бүртгэгдсэн байна (Зураг 7).



Зураг 7. Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдын эзлэх хувь, 2025 он

Зоонозын өвчний сэжигтэй тохиолдлын тоо өмнөх оноос 16,9%-иар буурсан бол сүүлийн 5 жилийн дунджаас 2,2%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ онд тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдлын тоо өмнөх оноос 75% хувиар нэмэгдсэн байна. Шинээр гахайн стрептококкын халдвар бүртгэгдсэн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоон үзүүлэлт, 2020-2025 он

Зоонозын өвчүүд	2020	2021	2022	2023	2024	2025	Өмнөх оноос	Сүүлийн 5 жилийн дунджаас
Тарваган тахал	22	4	6	15	8	14	6.0	3.0
Боом	4	5	5	12	5	7	2.0	0.8
Хачигт энцефалит	85	29	49	100	77	39	-38.0	-29.0
Хачигт боррелиоз	83	4	35	41	19	5	-14.0	-31.4
Хачигт риккетсиоз	860	218	497	415	380	383	3.0	-91.0
Хумхаа	4	4	3	26	9	8	-1.0	-1.2
Галзуугийн эрсдэлд өртсөн	95	39	65	370	449	327	-122.0	123.4
Денге чичрэг	0	0	11	1	0	0	0.0	-2.4
Бэтэг	25	6	6	20	18	23	5.0	8.0
Бруцеллёз	3	0	2	3	12	1	-11.0	-3.0
Ям	0	0	1	0	0	0	0.0	-0.2
Хулгана тахал	0	0	0	1	0	0	0.0	-0.2
Лептоспироз	0	0	6	0	0	1	1.0	-0.2
Токсоплазмоз	0	0	0	0	1	1	0.0	0.8
Гахайн стрептококк	0	0	0	0	0	1	1.0	1.0
Холер	0	0	0	0	0	3	3.0	3.0
Нийт	**1181**	**309**	**686**	**1004**	**978**	**813**	-165.0	-18.6

2025 онд улсын хэмжээнд 226 удаагийн мэрэгч амьтны дуудлага бүртгэгдэж, 718 амьтны сорьц шинжилснээс 88,3% тарвага, 10,0% тарваганы түүхий эд, 0,4% сарьсан багваахай, 0,7% гэрийн хулгана, 0,3% шувуу, 0,1% зурам, 0,1% харх байна.

Зоонозын өвчний амьтны сэжигтэй дуудлага өмнөх оноос 33,3% (339)-иар буурсан, сүүлийн таван жилийн дунджаас 2,2%-иар өссөн үзүүлэлттэй байна (Зураг 8).

Дуудлагаар 706 тарвага, тарваганы түүхий эд шинжилсний 97,0% нь хяналт шалгалтаар зөрчлийн улмаас хураагдсан байна. Хураагдсан амьтдыг лабораторийн шинжилгээнд хамруулж, тархвар судлалын холбогдолгүй болохыг тогтоосон.



Зураг 8. Мэрэгчийн дуудлагын тоон үзүүлэлт, 2021-2025 он

Дуудлага бүртгэгдсэн аймаг, хотоор авч үзэхэд 75,7 хувь (171) Нийслэлд, 9,3 хувь (21) нь Баян-Өлгий аймагт, 15,0 хувь нь (34) Баянхонгор, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгуудад бүртгэгдсэн байна (Зураг 9).



Зураг 9. Мэрэгчийн дуудлагад үйлчилсэн тоо, аймгаар, 2025 он

Улаанбаатар хотод бүртгэгдсэн 171 удаагийн мэрэгч амьтны дуудлагаар 695 мэрэгч амьтан хураагдсан байна. Эдгээрийн гарал үүслийг тогтооход Говь-Алтай, Архангай аймгуудаас агнасан, тээвэрлэсэн мэрэгч амьтны тоо өндөр байна (Зураг 10).



Зураг 10. ЗӨСҮТ-ийн мэрэгчийн дуудлагаар хураагдсан амьтны тоо, аймгаар, 2025 он

2.3. ЗООНОЗЫН ХҮНИЙ ӨВЧЛӨЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт бүртгэгдсэн сэжигтэй тохиолдлын 11,6% (94) нь эмнэлзүй, тархвар судлал, лабораториийн шинжилгээгээр онош батлагдсан. Мөн тус төвд бүртгэгдээгүй боловч онош нь баталгаажиж улсын мэдээнд мэдээлэгдсэн брүцеллёзын халдварын 55 тохиолдлыг нэмж тооцоход 2025 онд зоонозын хүний өвчлөлийн нийт 149 тохиолдол батлагдсан байна. Нийт батлагдсан тохиолдлыг аймгаар харьцуулж үзэхэд хүний өвчлөлийн 23,5% (35) Улаанбаатар хотод, 17,4% (26) Дорнод, 11,4% (17) Архангай аймгуудад бүртгэгдсэн нь нийт улсын дүнгийн 52,3 хувийг эзэлж байна. Дорноговь, Сүхбаатар аймгуудад өвчлөл бүртгэгдээгүй байна (Зураг 11).



Зураг 11. Зоонозын хүний өвчлөлийн батлагдсан тохиолдлын тоо, аймгаар, 2025 он

Энэ онд 149 хүний өвчлөл батлагдсанаас тарваган тахал, боом, гахайн стрептококк (Streptococcus sius) тус бүр 0,7 (1), хачигт халдвар 53,7% (80), хумхаа 4,0% (6), бэтэг 3,4% (5), брүцеллёз 36,9% (55) тус тус эзэлж байна.

Дорнод аймагт брүцеллёзын халдвар хамгийн өндөр буюу 24 тохиолдол батлагдсан байна.

Нийт өвчлөлөөс хачигт халдвар 53,7% (80) эзэлж байгаагаас хачигт риккетсиоз 49,0% (73), хачигт энцефалит 4,0% (6), хачигт борреллиоз 0.7% (1) тус тус эзэлж байна. Улаанбаатар хот (18) болон Архангай аймагт (14) хачигт риккетсиозын халдвар хамгийн өндөр байна.

Хөвсгөл аймагт тарваган тахал өвчнөөр 1, Улаанбаатар хотод бэтэг өвчнөөр 1, нийт 2 нас баралт бүртгэгджээ (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Зоонозын хүний өвчлөлийн тоо, өвчний төрөл, аймгаар, 2025 он

№	Аймаг	Тарваган тахал	Боом	Галзуу	Хачигт риккетсиоз	Хачигт энцефалит	Хачигт боррелиоз	Хумхаа	Бэтэг	Гахайн стрептококк	Брүцеллёз	Нийт	Нас баралт
1	Архангай	0	**1**	0	**14**	0	0	0	0	0	**2**	**17**	0
2	Баян-Өлгий	0	0	0	0	0	0	0	**1**	0	0	**1**	0
3	Баянхонгор	0	0	0	**3**	0	0	0	**2**	0	0	**5**	0
4	Булган	0	0	0	**3**	0	0	0	0	0	0	**3**	0
5	Говь-Алтай	0	0	0	**7**	0	0	0	0	0	0	**7**	0
6	Говьсүмбэр	0	0	0	0	0	0	0	0	0	**1**	**1**	0
7	Дархан-Уул	0	0	0	0	0	**1**	0	0	0	**2**	**3**	0
8	Дорноговь	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
9	Дорнод	0	0	0	**2**	0	0	0	0	0	**24**	**26**	0
10	Дундговь	0	0	0	**2**	0	0	0	0	0	0	**2**	0
11	Завхан	0	0	0	**2**	0	0	0	0	0	**7**	**9**	0
12	Орхон	0	0	0	0	**1**	0	0	0	0	**2**	**3**	0
13	Өвөрхангай	0	0	0	**6**	0	0	0	0	0	0	**6**	0
14	Өмнөговь	0	0	0	**1**	0	0	0	0	0	0	**1**	0
15	Сүхбаатар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	0	0	0	**2**	**2**	0	0	0	0	0	**4**	0
17	Төв	0	0	0	0	0	0	0	0	0	**2**	**2**	0
18	Увс	0	0	0	**2**	0	0	0	0	0	**3**	**5**	0
19	Ховд	0	0	0	**5**	0	0	0	0	0	**5**	**10**	0
20	Хөвсгөл	**1**	0	0	**4**	0	0	0	0	0	0	**5**	**1**
21	Хэнтий	0	0	0	**2**	0	0	0	0	0	**2**	**4**	0
22	Улаанбаатар	0	0	0	**18**	**3**	0	**6**	**2**	**1**	**5**	**35**	**1**
	Улсын дүн	**1**	**1**	0	**73**	**6**	**1**	**6**	**5**	**1**	**55**	**149**	**2**

Тайлбар: Брүцеллёзын өвчлөлийн тоог Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны жилийн эцсийн статистик мэдээллээс авав.

Сүүлийн 10 жилийн өвчлөлийн үзүүлэлтээс харахад 2017 онд зоонозын өвчлөл 486 буюу хамгийн их бүртгэгдсэн бол 2021 он буюу ковидын цар тахлын үед өвчлөл хамгийн бага (70) бүртгэгдсэн байна. 2025 оны хувьд сүүлийн 10 жилийн дунджаас 35.7%-иар буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Зоонозын хүний өвчлөлийн тоо, өвчний төрлөөр, 2016-2025 он

Өвчний нэр	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Сүүлийн 10 жилийн дундаж	2025
Тарваган тахал	3	0	1	0	2	6	1	2	5	0	2	1
Боом	7	2	1	0	1	0	1	2	3	3	2	1
Хачигт энцефалит	40	52	62	32	19	20	1	8	34	15	28.3	6
Хачигт боррелиоз	17	78	46	24	17	13	5	16	3	1	22	1
Хачигт риккетсиоз	137	196	357	203	139	182	60	122	144	93	163.3	73
Галзуу	0	0	0	0	0	1	0	0	1	0	0.2	0
Хумхаа	1	3	2	0	1	2	1	1	22	6	3.9	6
Бэтэг	0	0	17	25	4	4	1	1	2	5	5.9	5
Бруцеллёз	0	0	0	0	0	0	0	0	0	37	3.7	55
Ям	0	0	0	0	0	0	0	1	0	0	0.1	0
Гахайн стрептококк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
Денге чичрэг	0	1	0	1	0	0	0	0	0	0	0.2	0
Баруун нилийн чичрэг	1	0	0	0	0	0	0	0	0	0	0.1	0
Нийт	**206**	**332**	**486**	**285**	**183**	**228**	**70**	**153**	**214**	**160**	**231.7**	**149**

Зоонозын өвчний нас баралт жилд дунджаар 2-3 бүртгэгдэж, 2017, 2020, 2023 онуудад өндөр байжээ. 2025 онд тарваган тахал болон шимэгчээр дамжих анзаарагддагүй халдвар болох бэтэг өвчний нас баралт бүртгэгдсэн байна (Зураг 12).



Зураг 12. Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол, өвчлөл, нас баралтын тоо, 2016-2025 он

2025 онд бүртгэгдсэн зоонозын хүний өвчлөл 10000 хүн амд 0,4 байгаа нь өмнөх онтой ижил түвшинд, сүүлийн 10 жилийн дунджаас 0,28-аар буурсан байна (Зураг 13).

Хүний өвчлөл сүүлийн жилүүдэд буурч байгаа ч зарим өвчлөл зөөвөрлөгдөн орж ирэхийн зэрэгцээ шинэ халдвар бүртгэгдэж байна.



Зураг 13. Зоонозын хүний өвчлөл, 10000 хүн амд, 2016-2025 он

Тарваган тахлын хүний өвчлөлийн мэдээлэл

Монгол улсад 2025 онд тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын дүүдлага 14 бүртгэгдэж, лабораторийн шинжилгээгээр 1 тохиолдол батлагдаж, нас барсан. Сэжигтэй тохиолдлын тоо сүүлийн 10 жилийн дунджаас 47,4%-иар өссөн ба Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Орхон, Ховд, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдсэн (Зураг 14).



Зураг 14. Тарваган тахлын хүний өвчлөлийн тоо , 2016-2025 он

Тарваган тахлын хүний өвчлөл 1970 оноос хойш Монгол улсад нийтдээ 222 тохиолдол бүртгэгдэж, нийт бүртгэгдсэн өвчлөлийн нас баралтын түвшин 39,6% байна. Тарваган тахал өвчний батлагдсан тохиолдлыг 10 жилээр нь харьцуулж үзэхэд 1979-1999 онд хамгийн өндөр буюу нийт тохиолдлын 38,3% (85), нь бүртгэгдэж, 1970-1979 онд нас баралтын түвшин 62,5 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байжээ. Харин 2020-2025 оны байдлаар нийт 15 тохиолдол бүртгэгдэж, нас баралтын түвшин 33,3% байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Тарваган тахлын батлагдсан тохиолдлын тоо, нас баралт, 1970-2025 он

Он	Тохиолдлын тоо	Нас баралт	Нас баралтын хувь
1970-1979	16	10	62.5
1980-1989	51	15	29.4
1990-1999	85	41	48.2
2000-2009	44	13	29.5
2010-2019	11	4	36.4
2020-2025	15	5	33.3
Нийт	222	88	39.6

2024 онд тарваган тахлын хүний өвчлөл бүртгэгдэж байгаагүй бол 2025 онд 1 бүртгэгдсэн нь 10000 хүн амд 0,003 тохиолдол байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Тарваган тахал өвчний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он

№	Аймаг	А 20 Тарваган тахал /А20				Нас баралт
		Өвчлөл		10 000 хүн амд		
		2024	2025	2024	2025	
1	Архангай	0	0	0.0	0.0	0
2	Баян-Өлгий	0	0	0.0	0.0	0
3	Баянхонгор	0	0	0.0	0.0	0
4	Булган	0	0	0.0	0.0	0
5	Говь-Алтай	0	0	0.0	0.0	0
6	Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0
7	Дархан-Уул	0	0	0.0	0.0	0
8	Дорноговь	0	0	0.0	0.0	0
9	Дорнод	0	0	0.0	0.0	0
10	Дундговь	0	0	0.0	0.0	0
11	Завхан	0	0	0.0	0.0	0
12	Орхон	0	0	0.0	0.0	0
13	Өвөрхангай	0	0	0.0	0.0	0
14	Өмнөговь	0	0	0.0	0.0	0
15	Сүхбаатар	0	0	0.0	0.0	0
16	Сэлэнгэ	0	0	0.0	0.0	0
17	Төв	0	0	0.0	0.0	0
18	Увс	0	0	0.0	0.0	0
19	Ховд	0	0	0.0	0.0	0
20	Хөвсгөл	0	**1**	0.0	**0.07**	**1**
21	Хэнтий	0	0	0.0	0.0	0
Аймгийн дүн		0	**1**	0,0	**0,07**	**1**
22	Улаанбаатар хот	0	0	0.0	0.0	0
Улсын дүн		0	**1**	0,0	**0,003**	**1**

Тарваган тахлын байгалийн голомт

2025 онд ЗӨСҮТ болон ЗӨСТ нь тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээний төлөвлөгөөт ажлын хүрээнд улсын хэмжээнд голомттой аймгийн 96,1% (17), сумдын 33,6% (46)-ийг хамруулсан байна. Шинжилгээнд нийт 1631100 га талбайг хамруулж 1642 мэрэгч амьтан, 211 зэм үхдэл, 1225 махчин шувууны гулигдас, 3696 гадны шимэгчийг цуглуулан шинжилгээнд хамруулсан. Үүнээс 4 аймгийн 7 сумын нутгаас 23 өсгөвөр илрүүлсэн байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар жилд дунджаар 1869575 га талбайг шинжилгээнд хамруулжээ (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээний үзүүлэлт, 2021-2025 он

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	5 жилийн дундаж
1	Аймаг	13	15	16	17	17	15,6
2	Сум	49	63	45	58	46	52
3	Шинжилсэн талбай /га/	1884630	2080945	1820763	1930439	1631100	1869575
4	Гулигдас	2129	2274	1746	1575	1225	1789,8
5	Зэм үхдэл	214	230	464	196	211	263
6	Шинжилсэн шимэгч	6846	7279	4908	6977	3696	5941,2
7	Шинжилсэн амьтан	2418	2829	2192	2440	1642	2304,2
8	Илэрсэн өсгөвөр	18	23	37	6	23	21,4

Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан бүс нутгийн тарваган тахал өвчний үндсэн болон дэд агуулагчийн нягтшил мэрэгч бүрт үзвэл монгол тарвага 1 га талбайд дунджаар 2,7 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 33%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин дэд агуулагч урт сүүлт зурам 1 га талбайд 2,5, огдой 1 га талбайд 2, үлийн цагаан оготно 4,6 тус тус ноогдож байгаа нь өмнөх онтой харьцуулахад зурам 59,7%, огдой 28,6%, үлийн цагаан оготно 46,5%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна (Зураг 15).



Зураг 15. 1 га-д ногдох мэрэгчийн нягтшил, 2021-2025 он

2025 онд 4 аймгийн 7 сумын нутагт хамрагдах байгалийн голомтоос тарваган тахлын өсгөвөр 23 -ыг илрүүлж, 171000 га талбайд тарваган тахлын байгалийн голомт идэвхтэй байгааг тогтоолоо. Энэ нь өмнөх оноос 117000 га талбайгаар өссөн байна (Зураг 16).



Зураг 16. Байгалийн голомтын тандалт шинжилгээгээр илэрсэн тарваган тахлын өсгөврийн тоо, 2016-2025 он

2026 оны тарваган тахал өвчний аюулын зэрэглэл

Тарваган тахлын аюулын зэрэглэлээр А зэрэглэлд 9 аймгийн 28 сум, Б зэрэглэлд 13 аймгийн 29 сум, В зэрэглэлд 14 аймгийн 26 сум, нийт 15 аймгийн 83 сум тодорхойлогдсон байна (Зураг 17).



Зураг 17. Тарваган тахлын аюулын зэрэглэл, 2026 он

2.3.2. БООМ

Боомын хүний өвчлөлийн мэдээлэл

2025 онд Архангай, Говь-Алтай, Увс, Ховд аймгууд болон Улаанбаатар хотоос боомын хүний өвчлөлийн сэжигтэй 7 тохиолдол бүртгэгдсэнээс 1 тохиолдол эмнэл зүй болон лабораторийн шинжилгээгээр батлагдсан байна.

Боомын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлага өмнөх оноос 40 хувиар өссөн, сүүлийн 10 жилийн дунджаас 24,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна (Зураг 18).



*Зураг 18. Боомын х*үний өвчлөлийн тохиолдлын тоо, 2016-2025 он

Сэжигтэй 7 тохиолдол бүртгэгдсэнээс 14,3% (1) батлагдсан нь өмнөх оноос 3 дахин буурч 10000 хүн амд 0,003 байна (Хүснэгт 11).

Сүүлийн 10 жилийн хугацаанд 13 хүн боом өвчнөөр өвдөж, нас баралт бүртгэгдээгүй байна (Зураг 19).

Хүснэгт 11. Боомын хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он

Аймаг		А 22 Боом өвчин /Anthrax				Нас баралт
		Өвчлөл		10,000 хүн амд		
		2024	2025	2024	2025	
1	Архангай	0	**1**	0.0	**0.1**	0
2	Баян-Өлгий	0	0	0.0	0.0	0
3	Баянхонгор	0	0	0.0	0.0	0
4	Булган	0	0	0.0	0.0	0
5	Говь-Алтай	0	0	0.0	0.0	0
6	Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0
7	Дархан-Уул	0	0	0.0	0.0	0
8	Дорноговь	0	0	0.0	0.0	0
9	Дорнод	0	0	0.0	0.0	0
10	Дундговь	0	0	0.0	0.0	0
11	Завхан	0	0	0.0	0.0	0
12	Орхон	0	0	0.0	0.0	0
13	Өвөрхангай	0	0	0.0	0.0	0
14	Өмнөговь	0	0	0.0	0.0	0

15	Сүхбаатар	0	0	0.0	0.0	0
16	Сэлэнгэ	0	0	0.0	0.0	0
17	Төв	0	0	0.0	0.0	0
18	Увс	**2**	**0**	0.0	0.0	0
19	Ховд	0	0	0.0	0.0	0
20	Хөвсгөл	0	0	0.0	0.0	0
21	Хэнтий	0	0	0.0	0.0	0
Аймгийн дүн		**2**	**1**	0.0	**0.1**	0
22	Улаанбаатар	**1**	**0**	0.0	0.0	0
Улсын дүн		**3**	**1**	0.0	**0,003**	0

ДЭМБ-аас 10 мал амьтны өвчлөл бүртгэгдэхэд 1 хүний өвчлөл гарах магадлалтай гэж үздэг бөгөөд, эсрэгээрээ 1 хүний өвчлөл бүртгэгдэхэд малын дунд өвчлөл байх магадлалтай гэсэн үзэл баримтлал бий. Сүүлийн жилүүдэд хүн, малын өвлөл нэмэгдэх хандлагатай байна. Монгол улсад бүртгэгдсэн боомын хүний өвчлөлийг сүүлийн 10 жилийн байдлаар малын өвчлөлтэй харьцуулж үзэхэд 2023, 2024 онуудад боомын малын өвчлөл нэмэгдэхийн хэрээр хүний өвчлөл мөн адил өссөн үзүүлэлттэй байна (Зураг 19).



Зураг 19. Боомын хүн, малын өвчлөлийн тоо, 2016-2025 он

Боомын голомт, хяналтын шинжилгээ

2025 онд боомын голомтын болон хяналтын шинжилгээг 11 аймаг, Нийслэлд хийж гүйцэтгэсэн. Голомт хяналтын шинжилгээгээр нийт 1670 сорьц цуглуулан шинжилснээс Өвөрхангай аймгийн Хужирт сумаас боомын үүсгэгч илэрч, өсгөвөр гарган авсан. Хяналтын шинжилгээнд нийт 3581 сорьц цуглуулан шинжилсэн бөгөөд боомын үүсгэгч илрээгүй байна (Зураг 20).



Зураг 20. Шинжилсэн сорьцын тоо, 2016-2025 он

Боомын хяналтын шинжилгээнд нийт 3581 сорьц цуглуулснаас 69,1% арчдас, 6,4% арьс шир, 6,5% үс ноос, 14,3% хөрс бууц, 3,5% мах, сэг зэм, 0,3% үс дээжилсэн байна.

Аймгаар харьцуулахад Өвөрхангай аймаг арчдас 880 цуглуулсан бол Ховд, Баянхонгор, Өмнөговь аймгууд 5-6 төрлийн сорьц цуглуулан шинжилжээ. Говь-Алтай, Увс аймгуудад боомын хяналтын шинжилгээ хийгдээгүй байна.

Шинжилгээний дүнгээр боомын эмгэг төрөгч нян илрээгүй байна (Хүснэгт 12) .

Хүснэгт 12. Боомын хяналтын шинжилгээний дүн, сорьцын төрлөөр, аймгаар, 2025 он

№	Аймгууд	Цуглуулсан сорьцын нэр төрөл,тоо хэмжээ							Нийт	Үр дүн
		Арчдас	Арьс, шир	Үс, ноос	Хөрс	Бууц	Мах, сэг зэм	Ус		
1	Архангай	200							200	Үүсгэгч илрээгүй
2	Баян-Өлгий	60	5	5			10		80	Үүсгэгч илрээгүй
3	Баянхонгор	180	35	40	150	95	100		600	Үүсгэгч илрээгүй
4	Говь-Алтай								0	Хийгдээгүй
5	Дундговь	40	20	41					101	Үүсгэгч илрээгүй
6	Завхан								0	Үүсгэгч илрээгүй
7	Өвөрхангай	880							880	Үүсгэгч илрээгүй
8	Өмнөговь	40	80	70	45	155			390	Үүсгэгч илрээгүй
9	Сэлэнгэ	240		2	5				247	Үүсгэгч илрээгүй
10	Увс								0	Хийгдээгүй
11	Ховд	75	20	20	60		15	10	200	Үүсгэгч илрээгүй
12	Хөвсгөл	71							71	Үүсгэгч илрээгүй
13	Хэнтий	588	63	53					704	Үүсгэгч илрээгүй
14	Нийслэл								0	Үүсгэгч илрээгүй
15	ЗӨСҮТ	102	5	1					108	Үүсгэгч илрээгүй
Нийт		**2476**	**228**	**232**	**260**	**250**	**125**	**10**	**3581**	**Үүсгэгч илрээгүй**

Голомт хяналтын шинжилгээнд нийт 1670 сорьц цуглуулснаас 13,4% арчдас, 1,5% арьс шир, 10,7% үс ноос, 51,5% хөрс, 22,2% бууц, 0,4% мах, сэг зэм, 0,4% үс дээжилсэн байна.

Аймгаар харьцуулахад Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай аймгуудад шинжилсэн сорьцын тоо өндөр боловч Ховд аймаг шинжилгээнд зөвхөн арчдас цуглуулсан байна. Увс аймгийн цуглуулсан сорьцын тоо 14 буюу хамгийн бага байна. Баянхонгор, Өмнөговь аймгуудад боомын голомт хяналтын шинжилгээ хийгдээгүй байна.

Шинжилгээний дүнгээр Өвөрхангай аймгийн Хужирт сумын Хадан голын хөрснөөс боомын

үүсгэгч *Bac.Anthracis* эрэг тодорхойлогдсон (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Боомын голомт хяналтын шинжилгээний дүн, сорьцын төрлөөр, аймгаар, 2025 он

№	Аймгууд	Цуглуулсан сорьцын нэр төрөл,тоо хэмжээ							Нийт	Үр дүн
		Арчдас	Арьс, шир	Үс, ноос	Хөрс	Бууц	Мах, сэг зэм	Ус		
1	Архангай			15	90	60			165	Үүсгэгч илрээгүй
2	Баян-Өлгий		6	15	15	15		6	57	Үүсгэгч илрээгүй
3	Баянхонгор								0	Хийгдээгүй
4	Говь-Алтай	23	3	3	4				33	Үүсгэгч илрээгүй
5	Дундговь				100	10			110	Үүсгэгч илрээгүй
6	Завхан			12	75	60	3		150	Үүсгэгч илрээгүй
7	Өвөрхангай			100	100	100			300	Үүсгэгч илэрсэн
8	Өмнөговь								0	Хийгдээгүй
9	Сэлэнгэ				50				50	Үүсгэгч илрээгүй
10	Увс		4		6		4		14	Үүсгэгч илрээгүй
11	Ховд	200							200	Үүсгэгч илрээгүй
12	Хөвсгөл				215	105			320	Үүсгэгч илрээгүй
13	Хэнтий		12	14	155	20			201	Үүсгэгч илрээгүй
14	Нийслэл			20	50				70	Үүсгэгч илрээгүй
Нийт		**223**	**25**	**179**	**860**	**370**	**7**	**6**	**1670**	**Үүсгэгч илэрсэн**

2025 онд боомын голомт хяналтын шинжилгээ өмнөх оноос 27,1%, сүүлийн 5 жилийн дунджаас 13,5%-иар тус тус буурсан үзүүлэлттэй. Хяналтын шинжилгээ өмнөх оноос 12,9%, сүүлийн 5 жилийн дунджаас 3,0%-иар тус тус өссөн байна (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Боомын голомт, хяналтын шинжилгээний дүн, 2020-2025 он

Шинжилгээ	2020	2021	2022	2023	2024	2025	Өмнөх онтой харьцуулахад	Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс
Боомын голомт хяналт	2457	2088	1190	1630	2292	1670	27,1% ↓	13,5% ↓
Боомын хяналт	2023	3725	4030	4442	3170	3581	12,9% ↑	3,0% ↑
Нийт	**4330**	**5813**	**5520**	**6072**	**5462**	**5251**	**3,8% ↓**	**3,5% ↓**

2.3.3. ХАЧГААР ДАМЖИХ ХАЛДВАР

Хачгаар дамжих халдварт өвчний мэдээлэл

Улсын хэмжээнд 2025 онд зоонозын шалтгаант нийт 813 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэний 52,5% (427) -ийг хачгаар дамжих халдвар эзэлж байна. Хачигт халдварын сэжигтэй тохиолдол 21 аймаг, Нийслэлийн 115 сум, дүүрэгт бүртгэгдсэн. Үүнээс 383 (89,6%) нь хачигт риккетсиоз, 39 (9,1%) нь хачигт энцефалит, 5 (1,2%) нь хачигт боррелиозын сэжигтэй тохиолдол тус тус эзлэж байна. Сэжигтэй тохиолдлын тоог өмнөх онтой харьцуулахад хачигт халдварын тохиолдол өмнөх оноос болон сүүлийн 5 жилийн дунджаас 10-80% буурсан байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол (2020-2025 он)

Өвчний нэр	2020	2021	2022	2023	2024	2025	Өмнөх онтой харьцуулахад	Сүүлийн 5 жилийн дунджаас
Хачигт энцефалит	85	29	49	100	77	39	49,4% ↓	42,6% ↓
Хачигт боррелиоз	83	4	35	41	19	5	73,7% ↓	86,3% ↓
Хачигт риккетсиоз	860	218	497	415	380	383	0,8% ↑	19,2% ↓
Бүгд	1028	251	581	556	476	427	10,3% ↓	26,2% ↓

2025 онд бүртгэгдсэн хачигт халдварын эпидемиологийн мурүйг харахад эпидемиологийн 17-22 дугаар долоо хоногуудад оргил үе тохиож, 37 дугаар долоо хоногоос дуудлагын тоо намжсан байна (Зураг 21).



Зураг 21. Хачигт халдварын сэжигтэй тохиолдлын тархалтын муруй, 2025 он

Хачигт энцефалитын хүний өвчлөл

Улсын хэмжээнд хачигт энцефалит өвчний 39 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 15,4 хувь буюу 6 тохиолдол батлагдсан байна. Нийт батлагдсан тохиолдлоос 50 хувь нь Улаанбаатар хот, 33,3 хувь нь Сэлэнгэ аймагт, 16,7 хувь нь Орхон аймагт тус тус бүртгэгдсэн байна. 2025 онд хачигт энцефалитаар нас баралт бүртгэгдээгүй. Улсын хэмжээнд 10000 хүн амд ногдох өвчлөл 0,02 байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Хачигт энцефалит өвчний хүний өвчлөл, нас баралтын түвшин, 2024-2025 он

Аймаг		А 84 Хачгаар дамжих вируст энцефалит /Tick-born encephalitis				Нас баралт
		Өвчлөл		10,000 хүн амд		
		2024 онд	2025 он	2024 онд	2025 он	
1	Архангай	0	0	0.0	0.0	0
2	Баян-Өлгий	0	0	0.0	0.0	0
3	Баянхонгор	0	0	0.0	0.0	0
4	Булган	0	0	0.0	0.0	0
5	Говь-Алтай	0	0	0.0	0.0	0
6	Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0
7	Дархан-Уул	**3**	0	0.3	0.0	0
8	Дорноговь	0	0	0.0	0.0	0
9	Дорнод	0	0	0.0	0.0	0
10	Дундговь	0	0	0.0	0.0	0
11	Завхан	0	0	0.0	0.0	0
12	Орхон	**1**	**1**	**0.1**	**0.08**	0
13	Өвөрхангай	0	0	0.0	0.0	0
14	Өмнөговь	0	0	0.0	0.0	0
15	Сүхбаатар	0	0	0.0	0.0	0
16	Сэлэнгэ	**5**	**2**	**0.5**	**0.19**	0
17	Төв	0	0	0.0	0.0	0
18	Увс	0	0	0.0	0.0	0
19	Ховд	0	0	0.0	0.0	0
20	Хөвсгөл	0	0	0.0	0.0	0
21	Хэнтий	0	0	0.0	0.0	0
Аймгийн дүн		**9**	**3**	**0,1**	**0.02**	0
22	Улаанбаатар	**6**	**3**	0.0	0.02	0
Улсын дүн		**15**	**6**	**0,1**	**0.02**	0

Хачигт риккетсиозын хүний өвчлөл

Хачигт риккетсиозын 383 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэний 19% (73) нь батлагдсан ба 14 аймаг, Улаанбаатар хотод өвчлөл бүртгэгдсэн. Нийт батлагдсан тохиолдлыг аймгаар харьцуулж үзэхэд Улаанбаатар хотод 18, Архангай аймагт 14 тохиолдол бүртгэгдсэн нь хамгийн өндөр байна. Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сүхбаатар, Төв аймгуудад өвчлөл бүртгэгдээгүй байна (Зураг 22).



Зураг 22. Хачигт риккетсиозын өвчлөл, аймгаар, 2025 он

Улсын хэмжээнд хачигт риккетсиозын 73 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 21,5%-иар буурсан, өвчлөлийн түвшин 10,000 хүн амд 0,2 байна. Хачигт риккетсиозын шалтгаант нас баралт бүртгэгдээгүй (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Хачигт риккетсиозын тохиолдлын тоо, нас баралтын түвшин, 2024-2025 он

№	Аймаг	А 77 Хачигт риккетсиоз /Tick-Borne rickettsioses /				Нас баралт
		Өвчлөл		10,000 хүн амд		
		2024 онд	2025 он	2024 онд	2025 он	
1	Архангай	10	14	1.1	1.5	0
2	Баян-Өлгий	1	0	0.1	0.0	0
3	Баянхонгор	4	3	0.5	0.3	0
4	Булган	0	3	0.0	0.5	0
5	Говь-Алтай	5	7	0.9	1.2	0
6	Говьсүмбэр	0	0	0.0	0.0	0
7	Дархан-Уул	0	0	0.0	0.0	0
8	Дорноговь	0	0	0.0	0.0	0
9	Дорнод	14	2	1.7	0.2	0
10	Дундговь	2	2	0.4	0.4	0
11	Завхан	6	2	0.8	0.3	0
12	Орхон	0	0	0.0	0.0	0
13	Өвөрхангай	3	6	0.3	0.5	0
14	Өмнөговь	1	1	0.1	0.1	0
15	Сүхбаатар	1	0	0.2	0.0	0
16	Сэлэнгэ	4	2	0.4	0.2	0
17	Төв	2	0	0.2	0.0	0
18	Увс	0	2	0.0	0.2	0
19	Ховд	4	5	0.4	0.5	0
20	Хөвсгөл	7	4	0.5	0.3	0
21	Хэнтий	2	2	0.3	0.3	0

Аймгийн дүн		66	55	**0.2**	0,3	0
22	Улаанбаатар	27	18	0.1	0.1	0
Улсын дүн		93	73	**0.5**	0,2	0

Хачигт боррелиозын хүний өвчлөлийн мэдээлэл

